



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2023/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Улиастай сум	Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
2024 он	Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

Харуулах № 14 № 59

Тайлбар: _____

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АМГАЛАН-Д

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын нь 2023 онд сум үүсэн байгуулагдсаны түүхэн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар сумын Улаан загалмайн нийгэмлэгт дэмжлэг үзүүлсэн, аймгийн Авто тээврийн газраас томилолтоор ажилласан албан хаагчдын буудал, хоолны мөнгийг төсвөөс төлсөн, сумын хүндэт тэмдгийн дагалдах шагналд хөрөнгө зарцуулсан зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

1000000000

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Д.БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,298,486.00	128,873,586.00
33	АВЛАГА	7,720,000.00	500,000.00
335	Бусад авлага	7,720,000.00	500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,220,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	500,000.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,578,486.00	128,373,586.00
354	Хангамжийн материал	64,578,486.00	128,373,586.00
35410	Бичиг хэргийн материал	1,007,900.00	777,500.00
35420	Аж ахуйн материал	2,627,900.00	3,842,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,000,000.00
35450	Барилгын засварын материал	-	4,980,000.00
35470	Бусад хангамжийн материал	60,942,686.00	116,773,186.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,015,407,891.71	3,121,042,400.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,015,407,891.71	3,121,042,400.78
392	Биет хөрөнгө	1,507,309,891.71	2,608,673,567.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,334,215,894.00	2,384,319,523.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(182,446,227.76)	(264,679,619.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,804,800.00	299,404,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(106,675,127.65)	(133,312,766.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,042,759.00	168,142,759.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,112,525.71)	(76,264,885.77)

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,516,392.00	51,516,392.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,277,641.43)	(41,363,887.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	298,424,239.00	445,124,239.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(187,182,669.74)	(224,212,986.38)
393	Биет бус хөрөнгө	508,098,000.00	512,368,833.35
39301	Програм хангамж	1,850,000.00	6,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,025,000.00)	(1,454,166.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	507,273,000.00	507,273,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,087,706,377.71</u>	<u>3,249,915,986.78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,845,668,377.71</u>	<u>3,249,915,986.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,845,668,377.71	3,249,915,986.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	493,005,760.00	735,043,760.00
51101	Өмч: - төрийн	493,005,760.00	493,005,760.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,259,277,935.58	2,421,487,544.65
51210	Өмнөх үеийн үр дүн	1,259,277,935.58	1,259,277,935.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,162,209,609.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	93,384,682.13	93,384,682.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,845,668,377.71</u>	<u>3,249,915,986.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	703,275,842.00	2,406,938,574.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,387,195,129.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,387,195,129.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,387,195,129.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,387,195,129.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	703,275,842.00	1,019,743,445.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570,898,300.00	1,019,743,445.30
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570,898,300.00	1,019,743,445.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,377,542.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,957,282.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,420,260.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	782,468,066.02	1,244,728,965.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	782,468,066.02	1,244,728,965.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,277,200.02	1,241,412,365.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,592,052.64	457,218,759.00
210101	Үндсэн цалин	242,319,582.64	312,211,666.00
210102	Нэмэгдэл	48,219,710.00	123,711,393.00
210104	Урамшуулал	5,052,760.00	21,295,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,941,917.36	57,649,800.00
210201	Тэтгэврийн даатгал	24,316,567.80	39,337,139.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,860,769.40	4,578,154.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	703,275,842.00	1,019,743,445.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	703,275,842.00	1,019,743,445.30

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570,898,300.00	1,019,743,445.30
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570,898,300.00	1,019,743,445.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,377,542.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,957,282.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,420,260.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	671,917,693.00	1,008,343,445.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,917,693.00	1,008,343,445.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626,726,827.00	1,005,026,845.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,353,170.00	457,218,759.00
210101	Үндсэн цалин	242,808,075.00	302,061,213.00
210102	Нэмэгдэл	47,492,335.00	136,302,783.00
210104	Урамшуулал	5,052,760.00	18,854,763.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,180,800.00	57,649,800.00
210201	Тэтгэврийн даатгал	25,935,500.00	39,201,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,540,100.00	4,612,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,066,900.00	3,689,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	501,900.00	922,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,136,400.00	9,223,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,416,385.00	49,491,551.61
210301	Гэрэл, цахилгаан	3,852,665.00	6,565,903.61
210302	Түлш, халаалт	39,563,720.00	42,925,648.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,768,179.00	43,124,868.60
210401	Бичиг хэрэг	3,741,600.00	7,661,700.00
210402	Тээвэр, шатахуун	24,227,000.00	30,442,036.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,799,579.00	5,021,132.10

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,557,700.00	13,846,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,422,000.00
210604	Урсгал засвар	56,557,700.00	12,424,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,074,900.00	11,107,800.00
210702	Дотоод албан томилолт	7,074,900.00	11,107,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,395,300.00	127,688,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,370,000.00	120,406,174.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	149,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	226,903.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	116,400.00	-
210807	Газрын төлбөр	138,300.00	6,906,575.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,980,393.00	244,898,589.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,676,993.00	244,748,589.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,190,866.00	3,316,599.79
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,190,866.00	3,316,599.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,190,866.00	3,316,599.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,358,149.00	11,400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,358,149.00	11,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,358,149.00	11,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,358,149.00	11,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,358,149.00	11,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(31,358,149.00)	(11,400,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	1,259,277,935.58	2,087,706,377.71
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	1,259,277,935.58	2,087,706,377.71
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	1,259,277,935.58	2,087,706,377.71
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	1,259,277,935.58	2,087,706,377.71
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	1,259,277,935.58	2,087,706,377.71
D08	Тайлант үеийн үр дүн			1,162,209,609.07	1,162,209,609.07
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,043,760.00	93,384,682.13	2,421,487,544.65	3,249,915,986.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985445200.00	971806560.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985445200.00	960406560.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	985445200.00	960406560.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460534800.00	457218759.00
210101	Үндсэн цалин	334052000.00	302061213.00
210102	Нэмэгдэл	120260500.00	136302783.00
210104	Урамшуулал	6222300.00	18854763.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57649800.00	57649800.00
210201	Тэтгэврийн даатгал	39521800.00	39201900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4532000.00	4612000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3625600.00	3689600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	906400.00	922400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9064000.00	9223900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47979100.00	49271551.61
210301	Гэрэл, цахилгаан	4455600.00	6345903.61
210302	Түлш, халаалт	43523500.00	42925648.00

2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	44041000.00	42151968.60
210402	Тээвэр, шатахуун	6411700.00	7661700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30041400.00	29469136.50
		7,587,900.00	5,021,132.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,424,500.00	13,846,500.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	1,422,000.00
		12,424,500.00	12,424,500.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	10,413,800.00	10,348,800.00
		10,413,800.00	10,348,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,888,000.00	88,482,803.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	81,200,000.00	81,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	560,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	469,100.00	149,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,700.00	226,903.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	73,800.00	
210807	Газрын төлбөр	203,400.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,138,300.00	6,906,575.00
		15,700.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	253,514,200.00	241,436,378.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	253,364,200.00	241,286,378.00
		150,000.00	150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
		-	11,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		
		-	11,400,000.00
222001	Тоног төхөөрөмж		11,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
		985,445,200.00	975,123,160.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
		985,445,200.00	975,123,160.00
132001	Орон нутгийн төсвөөс	985,445,200.00	975,123,160.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,620,285.30	44,620,285.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,620,285.30	44,620,285.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,620,285.30	44,620,285.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,000.00	220,000.00
210301	Гэрэл, цахилгаан	220,000.00	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	972,900.00	972,900.00
210402	Тээвэр, шатахуун	972,900.00	972,900.00
2107	Томилолт, зочны зардал	759,000.00	759,000.00
210702	Дотоод албан томилолт	759,000.00	759,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,206,174.00	39,206,174.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,206,174.00	39,206,174.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,462,211.30	3,462,211.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,462,211.30	3,462,211.30
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,620,285.30	44,620,285.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,620,285.30	44,620,285.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,620,285.30	44,620,285.30

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр,

төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд 6 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 82.6 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,162.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			

Авлага	7,720.0	500.0	-7,220.0
Бараа материал	64,578.5	128,373.6	63,795.1
Үндсэн хөрөнгө	2,015,407.9	3,121,042.4	1,105,634.5
Нийт хөрөнгө	2,087,706.4	3,249,916.0	1,162,209.6
Өр төлбөр	0	0	-2,039.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,087,706.4	3,249,916.0	1,162,209.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,087,706.4	3,249,916.0	1,162,209.6

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд үүссэн авлагыг барагдуулсан,
- ✓ Бараа материалын үлдэгдэл өссөн нь сумын 100 жилийн ойн хүрээнд хандиваар ирсэн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, зудын байдалд шилжсэнтэй холбоотой бэлтгэсэн өвс тэжээл, хивэг зэргийг орлогод бүртгэсэн,
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь сумын 100 жилийн ойн хүрээнд бий болсон хандив тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил, ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн ажил, тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг бүртгэсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 307.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хорооны үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны зардал, орон нутгийн нөөц хөрөнгө /засаг даргын нөөц сан/, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ гэсэн 6 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 985.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 975.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 3.3 сая төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 99.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	544,158.4	517,866.3	26,292.1	
2	Баг, хорооны үйл ажиллагаа	123,276.0	122,332.0	944.0	
3	Мэдээлэл сурталчилгаа	1,200.0	1,200.0	0	
4	Засаг даргын нөөц сан	120,055.8	136,305.7	-16,249.9	
5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	116,755.0	114,102.7	2,652.3	
6	Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	80,000.0	80,000.0	0	
	ДҮН	985,445.2	971,806.7	13,638.8	

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 44.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь аймгийн ОНХС-аас эрх шилжсэн ажлын санхүүжилт 17.0 сая төгрөг, зас засварын санхүүжилт 20.0 сая төгрөг, мал тооллогын шатахууны зардал 2.6 сая төгрөг, зудын хүнд нөхцөлд айл өрхөд далпуу татах зардал 3.0 сая, бусад орлого 2.0 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 3/71 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөөр сонгож 2,087.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 31.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 3,249.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 48.7 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар Сумын 100 жилийн ойн 2023 онд тохиохтой уялдуулан түүхэн ном хийх ажлын урьдчилгаа санхүүжилтийг төсвөөс төлсөн 3.0 сая төгрөгийн, төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 4.3 сая, 2023 онд хийх ажлын санхүүжилтийг урьдчилан олгосон 7.0 сая, засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан 4.5 сая төгрөгийн, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын хүрээнд зарцуулаагүй, шуудан холбоо гэрэл цахилгааны зардлаас техникийн нөхцөлийн төлбөр төлсөн, СХС-ийн программын сунгалтыг урсгал зардлаас гаргасан, аймгийн засаг даргын нөөц сангаас олгосон хөрөнгийн зарцуулалт анхан шатны баримтгүй, сумын засаг даргын захирамжаар зарцуулсан ажлуудын баримтын бүрдүүлэлт хангалтгүй, байгалийн нөхөн төлбөрийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,000.0	1	3,000.0	100
Албан шаардлага	3	15,764.0	3	15,764.0	100
Зөвлөмж	4	48,260.7	4	48,260.7	100
Нийт дүн	8	67,024.7	8	67,024.7	100

Шийдвэрийн биелэлтийг FAS системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, дансны бичилт буруу хийсэн 11.4 сая төгрөг байна.

Аудитаар нийт 7.3 сая төгрөгийн зөрчил илэрсний 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, аймгийн Авто тээврийн газраас очсон алба хаагчдын буудал, хоолны мөнгийг төлсөн 1.3 сая төгрөгийн зөрчил байна.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Сумын Улаан загалмайн нийгэмлэгт 1.0 сая төгрөгийн хандив өгсөн, сумын хүндэт тэмдгийн дагалдах шагналд 5.0 төгрөгийг олгосон зэрэг зөрчил байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, дансны бичилт буруу хийсэн	2	11,400.0			2	11,400.0	2	11,400.0						
ДҮН	2	11,400.0			2	11,400.0	2	11,400.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, аймгийн Авто тээврийн газраас очсон алба хаагчдын буудал, хоолны мөнгийг төлсөн	1	1,259.0	1	1,259.0								
Сумын Улаан загалмайн нийгэмлэгт хандив өгсөн	1	1,000.0			1	1,000.0						
Сумын хүндэт тэмдгийн дагалдах шагналд хөрөнгө зарцуулсан	1	5,000.0			1	5,000.0						
ДҮН	3	7,259.0	1	1,259.0	2	6,000.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил Дүн								
Нийт дүн								



БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР
 ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЖАЛБАА
 Д.БАТ-УНДРАА
 Х.БОЛДБААТАР

2024.02.23
 2024.02.23
 2024.02.23